

**“Багануур” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит
бус хурлын тэмдэглэл**

2015.01.23

Багануур

Багануур ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал 2015 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 16.10 цагт Монгол улс Улаанбаатар хот Багануур дүүрэг 3 хороо, Үйлдвэрийн хэсэгт байрлах Багануур ХК-ийн захиргааны төв байрны 2 дугаар давхрын хурлын танхимд хуралдав.

Тооллогын комиссын дарга Ч.Очирлхам хуралд ирсэн хувьцаа эзэмшигчдийн ирцийн бүртгэлийг танилцуулав. /Тооллогын комиссын нэгдүгээр тогтоолыг танилцуулав/

1. Компанийн нийт хувьцааны 75 хувийг эзэмшлийн төлөөлөл 15730770 ширхэг хувьцааг төлөөлж 35 тоот итгэмжлэлээр 99-р брокерийн пүүс дээр 4742 дугаартай Эрдэнэс Монгол ХХК-ийн Төлөөлөн Удирдах зөвлөлийн гишүүн Б.Жавхлан, Эрдэнэс Монгол ХХК-ийн Дэд захирал С.Цэлмэг
2. Жалцан овогтой Цэдэнсодном 502 ширхэг хувьцааг төлөөлж УБ49090113 регистртэй, 19-р брокерын пүүс 3715 бүртгэлийн дугаартайгаар
3. Дүгэрээ овогтой Түвшинтөгс 70 ширхэг хувьцааг төлөөлж УБ57092615 регистртэй, 29-р брокерын пүүс 4059 бүртгэлийн дугаартайгаар оролцож байна.

Тооллогын комиссын дарга Ч.Очирлхам хуралд бүртгүүлж оролцож буй 15731342 ширхэг хувьцаа нь 20974360 ширхэг хувьцааны 75,002 хувийг бүрдүүлж байгаа тул хурал хуралдах ирц бүрдсэн болохыг мэдээллэв.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг даргыг сонгоход Төрийн төлөөллийг хэрэгжүүлэх 75 хувийг эзэмшдэг итгэмжлэлээр томилогдсон “Эрдэнэс Монгол” ХХК-ийн ТУЗ-ийн гишүүн Б.Жавхлан, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Дэд захирал С.Цэлмэг нарыг дэвшүүлж санал хураахад хувьцаа эзэмшигчдийн 100 хувийн саналаар хурлын даргаар Б.Жавхланг сонголоо.

Хурлын дарга Б.Жавхлан: Хурлыг даргалж байгаагийн хувьд эхлээд хурлын дэг болон хэлэлцэх асуудлыг батлах нь зүйтэй. Хурлын дэгийг танилцуулья.

Д/д	ХУРЛЫН ДЭГ	ХУГАЦАА
1	Хурлын ирц бүртгэх /Тооллогын комисс/	10 минут
2	Хурлын ирц мэдээллэх /Зохион байгуулах комисс/	5 минут
3	Хувьцаа эзэмшигчдийн хурлын даргыг сонгох	5 минут

4	Хурлын дарга хурлын ажиллагааг нээж, хурлаар хэлэлцэх асуудал, хурлын дэгийг танилцуулах	10 минут
5	Хэлэлцэх асуудлыг дарааллын дагуу танилцуулж хэлэлцүүлэх	Асуудал тус бүрээр 30 хүртэл минут хэлэлцүүлэх
6	Хуралд оролцогсдын асуулт хариулт, санал, дүгнэлт авах	Хүн тус бүрээр 5 минут
7	Завсарлага	15 минут
8	Тооллогын комиссын тогтоолыг танилцуулах	5 минут
9	Хурлаас гарах шийдвэр, тогтоолын төслийг танилцуулах	15 минут
10	Хурлын ажиллагааг хаах	5 минут

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын дэгийг 100% саналтай батлав.

Хурлаар хэлэлцэх асуудлыг танилцууля.

1. Компанийн 2015 оны бизнес төлөвлөгөөг батлах тухай

Илтгэгч ТУЗ-ийн гишүүн Л.Ганболд

2. Эдийн засаг, нийгмийн хөгжлийн сангийн журам батлах тухай

Илтгэгч Захиргаа хүний нөөцийн хэлтсийн дарга Л.Шагдарсүрэн нар танилцуулах бөгөөд хурлын хэлэлцэх асуудалтай холбогдуулан санал хүсэлт байна уу?

Хурлын хэлэлцэх асуудлыг тооллогын комисс ажиллаж Тооллогын комиссыг хоёрдугаар тогтоолыг танилцуулж Хувьцаа эзэмшигчдийн 100%-ийн саналаар баталлаа.

Хувьцаа эзэмшигч С.Цэлмэг: “Эрдэнэс Монгол” ХХК-ийн удирдлагын зүгээс хоёр дахь асуудлыг хойшлуулах санал гаргасан Эдийн засаг нийгмийн хөгжлийн сангийн журмаар сангийн хөрөнгийг хөрөнгийг зарцуулах нь тодорхойгүй байгаа тул дараагийн хурал хүртэл хойшлуулах саналтай байна.

ТУЗ-ийн гишүүн Л.Ганболд: Энэхүү асуудлыг хэлэлцэх асуудлын хүрээнд шийдвэрлээд явах байх.

Хувьцаа эзэмшигч Ж.Цэдэнсодном: Энэ 2 асуудалтайгаа танилцаад хэлэлцэх асуудлаа батлаад тухайн асуудлыг хэлэлцэх бүр дээр саналаа хэлсэн нь зүйтэй байх.

Хурлын дарга Б.Жавхлан: Энэ 2 асуудалтайгаа танилцаад тухай бүр нь саналаа хэлээд явья. Хэлэлцэх асуудлаа батлах уу?

Хурлаар хэлэлцэх асуудлыг тооллогын комисс ажиллаж хувьцаа эзэмшигчдийн 100%-ийн саналаар баталлаа.

Хурлын дарга Б.Жавхлан: Хурлын дэгийн дагуу Компанийн 2015 оны бизнес төлөвлөгөөг ТУЗ-ийн гишүүн Л.Ганболд танилцуулна.

ТУЗ-ийн гишүүн Л.Ганболд: ТУЗ-ийн дарга Р.Жигжид уг асуудлыг танилцуулах байсан боловч итгэмжлэлээр миний бие танилцуулах болсон. Багануур ХК-ийн ТУЗ 2014 оны 11-р сарын 13 өдөр хуралдаж Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг хуралдуулах шийдвэр гаргасан. 2014 оны 11 сарын 20-ны өдрийн ТУЗ-ийн хурлаар компанийн гүйцэтгэх удирдлагын зүгээс 2015 оны бизнес төлөвлөгөөг оруулсан. ТУЗ-өөс дараах зүйлийг оруулахаар болсон.

- 1,9 тэрбум төгрөгийн зардлыг бууруулах
- Ажилчдын цалинг 18%-иар нэмэгдүүлсэн
- 2014 оны 12 сарын 3-ны өдөр Эрчим хүчний зохицуулах хорооноос Эрчим хүчний нүүрсний үнийг 25500 болгож 3000 төгрөгөөр нэмэгдүүлсний дагуу ТУЗ-ийн гишүүд нүүрсний үнийг нэмэгдүүлж Бизнес төлөвлөгөөнд оруул гэсэн үүргийг гүйцэтгэх удирдлагад өгсөн. Үүний дагуу зохих хэмжээний өөрчлөлт оруулсан. Ямар өөрчлөлт орсон гэхээр 10,8 тэрбум төгрөгийн ашиг, үйл ажиллагааны бус орлогоос 366 сая төгрөгийн ашиг орж ирж байгаа нийт 11,16 тэрбум төгрөгөөр бизнес төлөвлөгөө нэмэгдсэн. Багануур ХК-ийн 2015 онд олох нийт орлого маань 106 тэрбум 572 сая төгрөг, нийт 109 тэрбум 134 сая төгрөг алдагдал 2 тэрбум 562 сая төгрөгөөр тооцогдож байгаа. Үүн дээр тодорхой үнийн өсөлтүүд гарсан. Цахилгаан эрчим хүчний зардал 430 сая төгрөгөөр Дулааны эрчим хүчний үнэ 146 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн.

ТУЗ-ийн шийдвэрээр дараах зардлуудыг бууруулсан. Үүнд

- Туслах материалаас 295 сая
- Шатахууны зардлаас 8 сая
- Сэлбэг 20 сая
- Албан томилолтоос 27 сая
- ХАБЭА-н зардлаас 30 сая
- Бичиг хэргээс 1,2 сая
- Бусад зардлаас 515 сая
- Элэгдлийн зардлаас 13 сая
- Спорт нийгмийн арга хэмжээнээс 375 сая

Нэмэгдсэн зардал гэвэл цалингийн зардлыг 18 хувиар нэмснээр 1,6 тэрбум төгрөгөөр, Эрчим хүчний зардал 576 сая төгрөгөөр, зөвлөх үйлчилгээ зардал 45 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн байгаа. Бизнес төлөвлөгөөг илүү нарийвчилсан байдлаар компанийн санхүү эдийн засгийн хэлтсийн ахлах эдийн засагч Г.Нацагдорж танилцуулна.

Эдийн засагч Г.Нацагдорж Компанийн 2015 оны бизнес төлөвлөгөөг танилцуулсан.

Хурлын дарга Б.Жавхлан: Хүний хөгжлийн санд мөнгө байсан юм уу? Ямар төлбөрийг хаасан гэсэн бэ?

Эдийн засагч Г.Нацагдорж: Манай компани түлш шатахуун болон татварт нийт 10,1 тэрбум төгрөгийн өглөгтэй байсан үүнийг эхний ээлжинд хүний хөгжлийн сангаас суутгуулан тодорхой хугацааны дараа эргэж төлүүлэхээр шийдвэр гаргуулсан.

Хувьцаа эзэмшигч С.Цэлмэг: “Эрдэнэс Монгол” ХХК, “Эрдэнэс таван толгой” ХХК-ийн хүний хөгжил санд төвлөрүүлсэн мөнгөнөөс суутгал хийлгүүлсэн.

Хурлын дарга Б.Жавхлан: Компанийн бизнес төлөвлөгөөг Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал дээр хэр ярьсан бэ? Ямар шийдвэр гарсан бэ?

ТУЗ-ийн гишүүн Л.Ганболд: ТУЗ-ийн хурлаар хэлэлцээд зохих өөрчлөлтүүдийг оруулаад эцсийн байдлаар Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар батлуулахаар оруулж ирж байна.

Хурлын дарга Б.Жавхлан: Сүүлийн жилүүдэд парк шинэчлэлт хийгдсэн үү хийхээр ярьж байна уу?

Эдийн засагч Г.Нацагдорж: 2015 оны төлөвлөгөөнд хөрс тээврийн болон экскаваторууд нүүрс тээврийн машинуудад хөрөнгө оруулалт хийх асуудал ороогүй.

Санхүү эдийн засгийн хэлтсийн дарга Ч.Очирлхам: 2012 оны 12 сард парк шинэчлэлт хийсэн. Монгол Улсын Хөгжлийн банкнаас 9,8 хувийн хүүтэй нийтдээ 20-иод тэрбум төгрөгийн зээл авч хөрс тээврийн 4 машин, нүүрс тээврийн 4 машин, 1 бульдозер, тех дамжлагын байгууламжийн өргөтгөл 2,2 тэрбум төгрөгийн хэсэгчилсэн шинэчлэлт хийсэн. 2015 онд өөрсдийнхөө элэгдлийн зардлын хэмжээнд 17 тэрбум төгрөгт багтаан хөрөнгө оруулалтын зардал хийсэн, шинээр авах боломжгүй учраас хуучин ашиглалтын нас өндөртэй техникүүдийн засварын зардалд орохоор байгаа.

Хурлын дарга Б.Жавхлан: Зардал хэмнээд орлого бараг биелэсэн 99 хувьтай байна уу?

Санхүү эдийн засгийн хэлтсийн дарга Ч.Очирлхам: Хэмнэсэн биш бид үйлдвэрийнхээ тавьсан зорилтыг биелүүлээгүй 95 хувьтай явж байгаа өөрөөр хэлбэл хийх ёстой ажлаа хийгээгүй учраас энд тусгалаа олж байгаа.

Хурлын дарга Б.Жавхлан: Очирлхам даргаа 2015 оны төлөвлөгөө хэр үнэмшилтэй байгаа вэ?

Санхүү эдийн засгийн хэлтсийн дарга Ч.Очирлхам: Үнэмшилтэй яагаад гэвэл эрчим хүчний зориулалтаар нийлүүлж байгаа нүүрс маань манай нийт борлуулалтын орлогын 93 хувийг эзэлж байгаа ба тонн тутамд 3000 төгрөг нэмэгдсэн мөн дээр нь ДЦС-уудад нийлүүлдэг нүүрсний илчлэг чанараас хамаарч үнэ нэмэгдэж орох боломжтой учраас үндэслэлтэй.

Хурлын дарга Б.Жавхлан: Одоо урт хугацааны зээл хэр байгаа вэ?

Санхүү эдийн засгийн хэлтсийн дарга Ч.Очирлхам: Одоо манайд байгаа урт хугацаат зээлийн үлдэгдэл 43 тэрбум төгрөг байгаа.

Хурлын дарга Б.Жавхлан: Хаана хаанаас авсан зээл вэ вэ? Зээл төгрөгөөр байгаа юм уу?

Санхүү эдийн засгийн хэлтсийн дарга Ч.Очирлхам: Дэлхийн банк, Хөгжлийн банк, Японы сан зэргээс зээл авсан. Бүгд төгрөгт шилжүүлсэн.

Хурлын дарга Б.Жавхлан: Дэлхийн банкны зээлийг яаж хөрвүүлсэн бэ?

Санхүү эдийн засгийн хэлтсийн дарга Ч.Очирлхам: Бид нар Сангийн яаманд хүсэлт гаргасаны дагуу Засгийн газар 2010 онд шийдвэр гаргаж зээлийн валютуудыг тухайн үеийн ханшаар төгрөгт шилжүүлсэн. Үүнээс хойш төгрөгөөр зээлээ төлж байгаа. Нийт авсан зээл маань 60 гаран сая доллар байсан.

Хурлын дарга Б.Жавхлан: Ямар авлагууд байна. Дээрх авлагууд төлөгддөг биздээ

Санхүү эдийн засгийн хэлтсийн дарга Ч.Очирлхам: Дулаан станцуудаас авах нүүрсний авлага байна. Нийт авлагыг графикаар харуулсан. Дулааны станц 2, Багануурын дулааны станц 2-оос авах авлага хуримтлагдсан авлагууд байгаа.

Хурлын дарга Б.Жавхлан: Өглөгөө жил бүр барагдуулаад явж чадах уу? Хамгийн удаж байгаа өглөг хэдэн жил явсан байна.

Санхүү эдийн засгийн хэлтсийн дарга Ч.Очирлхам: Насжилтын хувьд бол 2012, 2013 оноос улбаажилж ирсэн 20 орчим тэрбум хүрэхгүй төгрөгийн өглөг байгаа. Хамгийн их өглөг үүсдэг зүйл бол түлш шатахуун, тэсрэх материалын өглөг байгаа. Бид тендер зарлаад шалгарсан компанидаа урьдчилгаа болон төлбөрөө төлж чадахгүй зээлээр авч дараа төлөх зэргээр өглөг их үүсдэг.

Хурлын дарга Б.Жавхлан: Хувьцаа эзэмшигчдээс асуух зүйл байна уу? 10 тэрбум төгрөгийн зээл авна гэсэн үү? Аль банкнаас авах вэ?

Санхүү эдийн засгийн хэлтсийн дарга Ч.Очирлхам: Зуны саруудад орлого багасгаж өвлийн бэлтгэл ажлыг хангах шаардлага тулгардаг. Бид энэ хугацаанд арилжааны банкуудад хандаж богино хугацааны 12-24 сарын хугацаатай авах шаардлагатай болдог.

ТУЗ-ийн гишүүн Л.Ганболд: ТУЗ-ийн гишүүдийн хувьд хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх байр суурьтай байсан. Шинэ тоног төхөөрөмж авах хүсэлтэй байсан ч санхүүгийн байдалтай уялдуулж хөрөнгө оруулалт тавиагүй. Нийт 13 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг эх үүсвэргүйгээр оруулж ирсэн. Түүнийг болиулсан.

Хурлын дарга Б.Жавхлан: Энэ жил та нарын төлөвлөсөн алдагдал чинь харьцангуй буурч ирж байгаа юм байна.

Санхүү эдийн засгийн хэлтсийн дарга Ч.Очирлхам: Нүүрсний үнэ нэмэгдсэн холбоотой алдагдал тодорхой хэмжээгээр буурсан.

Хурлын дарга Б.Жавхлан: 2,5 тэрбум төгрөгийн алдагдлаа барина гэж үзэж байна уу. Төлөвлөгөөний хувьд нилээд боломжийн санагдаж байна. Энэндээ барих хэрэгтэй.

Хувьцаа эзэмшигч С.Цэлмэг: Манай компанийн дотоод журмаар охин компаниудын ТУЗ-ийн хурлаар хэлэлцэх асуудлууд Нэгдсэн удирдлагын газраар ороод холбогдох хэлтэс газруудаар хянагдаад удирдамж өгч удирдамжийн дагуу ТУЗ хэлэлцдэг. Энэхүү зарчмын дагуу Багануур ХК бизнес төлөвлөгөө явсан бөгөөд “Эрдэнэс Монгол” ХХК-иас дүгнэлт гаргасан. Дүгнэлттэй танилцуулья.

“Эрдэнэс Монгол ХХК-ийн ХОСГ-ын захирал Э.Рашмаа дүгнэлтийг уншиж танилцуулсан.

Хувьцаа эзэмшигч С.Цэлмэг: Хөрөнгө оруулалт дээр тавьсан тусгай тоноглолтой машин гэж ямар машиныг хэлээд байна. Одоо ер нь зардлын 60-70 хувь

нь урсгал засварын зардал бий болгодог. парк шинэчлэлт асуудлыг хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд суулгасан уу?

Эдийн засагч Г.Нацагдорж Энд бол үндсэн ажилтай холбоотой машин байхгүй 50 тонны даацтай автокран 800 сая төгрөг, бордоо зуурагч тэсэлгээний машин 500 сая төгрөг, дугуй сарын машин 900 сая төгрөг, 2 ширхэг пикап 120 сая, 1 ширхэг фургон гм машинууд байгаа.

Хурлын дарга Б.Жавхлан: Өөр асууж тодруулах зүйл байна уу. 2015 оны бизнес төлөвлөгөө маань 106 тэрбум төгрөгийн орлоготой, 109 тэрбум төгрөгийн зардалтай, 2,5 тэрбум төгрөгийн алдагдалтай уулын ажил нэмэгдэж байгаа, нүүрс гаргалтын хэмжээ нэмэгдэж байгаа зэргээс харахад энэ төлөвлөгөөг батлах үндэслэлтэй гэж үзэж байна.

Компанийн 2015 оны бизнесийн төлөвлөгөөг батлах асуудал дээр тооллогын комисс ажиллаж тооллогын комиссын 3 дугаар тогтоолыг танилцуулсан.

Хурлын дарга Б.Жавхлан Төлөвлөгөө батлах тухай тогтоолын төслийг уншиж танилцуулан хувьцаа эзэмшигчдийн 100 хувийн саналаар баталлаа.

Хурлын дарга Б.Жавхлан: Хурлын хэлэлцэх асуудлын дарааллын дагуу Эдийн засаг нийгмийн хөгжлийн сангийн журам батлах тухай Захиргаа хүний нөөцийн хэлтсийн дарга Л.Шагдарсүрэн танилцуулна. Урьд нь компанид ийм сан байгаагүй юм уу? Уурхайчдын асуудлыг яаж шийдвэрлэж ирсэн бэ?

Захиргаа хүний нөөцийн хэлтсийн дарга Л.Шагдарсүрэн: 1117 ажилтан үндсэн орон тоон дээр ажиллаж байна. Нийт ажиллагсадын нийгмийн асуудлыг Хөдөлмөрийн дотоод журам, ҮЭНХ-той хамтран хэрэгжүүлэх Хамтын гэрээгээр зохицуулж ирсэн. Ажилтнуудад рлгож байгаа буцалтгүй тэтгэмж тусламж хөнгөлөл бусад урамшууллыг урсгал зардлаас санхүүжүүлж явж байна. Гэтэл амьдрал дээр энэ 2 эрх зүйн баримт бичгээр зохицуулах боломжгүй асуудлууд их гарч ирж байна. Манай нийт ажилчдын 38 хувь залуучууд. Эдгээр ажилчдын ихэнх нь орон сууцны асуудал бүрэн шийдэгдээгүй аав ээж, болон бусад айлын байр гэр түрээслэж суудаг. Манай удирдлагын хэмжээнд уулзалт зохион байгуулахад Засгийн газраас хэрэгжүүлж буй ипотекийн зээлд хамрагдах урьдчилгаа төлбөр байхгүйгээс хамрагдаж чадахгүй байгаа тухай болон нийт ажилчдын 98 хувь нь цалингийн зээлтэй, дээр нь хорт хавдар болон онош тогтоогдохгүй өвчний улмаас гадаадад эмчлүүлэх шаардлага тай болдог. Мөн төрийн дээд одон шагнал авахад түүнийг урамшуулах боломжгүй зэрэг олон асуудал тулгарч байна. Дээрх асуудлыг шийдвэрлэхээр зорилгоор Эдийн засаг нийгмийн хөгжлийн сангийн журмыг гаргах зайлшгүй шаардлага гарсан.

Энэхүү журмын төслийг 2013 оны 12-р сараас эхлэн боловсруулж ТУЗ-ийн хуралд 3 удаа танилцуулан хэлэлцүүлсэн. 2014 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн хурлаар журмын төслийг танилцуулан хэлэлцүүлж зохицуулах харилцааг тодорхой болгож дахин боловсруулах үүрэг өгсөн. Үүний дагуу журмын төслийг дахин боловсруулж 2014 оны 3 дугаар сарын 3-ны өдрийн хурлаар хэлэлцүүлсэн ба хурлын 3 тоот тэмдэглэлээр "Эдийн засаг нийгмийн хөгжлийн сангийн журам"-ын төслийг зарчмын хувьд дэмжиж "Эрдэнэс Монгол" ХХК-ийн төлөөлөл оролцсон хамтарсан ажлын хэсэг байгуулж Багануур ХК-ийн дүрэмд сантай байх эрх зүйн үндэслэлийг бий

болгох үүрэг өгсөн. Үүний дагуу хамтарсан ажлын хэсэг Багануур ХК-ийн Гүйцэтгэх захирлын тушаалаар байгуулагдаж компанийн дүрмийг толгой компанийн дүрэмд нийцүүлэн нэмэлт өөрчлөлт оруулан, санг бий болгох зорилгоор дүрэмд 1 дүгээр зүйлийн 1.3, 10 дугаар зүйлийн 10.3.1 дэх заалтуудыг шинээр оруулсан. Дүрмийн төслийг 2014 оны 4 дүгээр сарын 24-ний өдөр Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэн батлуулж хуулийн дагуу бүртгэх байгууллагад бүртгүүлэн мөрдөн ажиллаж байна. 2014 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн ТУЗ-ийн хурлаар журмын эрх зүйн үндэслэлийг бий болгон журмыг төслийг дахин танилцуулсан. Энэхүү хурлаас журмын төслийг дэмжиж "Эрдэнэс Монгол" ХХК-иас ирүүлсэн удирдамжийн дагуу Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын хэлэлцэх асуудлын жагсаалтанд оруулж шийдвэрлүүлэх үүрэг өгсөн үүний дагуу журмын төслийг оруулж байна.

Энэхүү журмаар компани нь үндсэн үйл ажиллагааны болон үйл ажиллагааны бус орлогыг давуулан биелүүлж, эдийн засаг, нийгмийн хөгжлийн бодлого, стратеги төлөвлөгөө, бизнес төлөвлөгөөний хүрээнд хуримтлал нөөц /цаашид Эдийн засаг, нийгмийн хөгжлийн сан гэх/-ийг бүрдүүлэн, компанийн сайн засаглал, хүний нөөц, ажилтан ажиллагсадын нийгмийн хамгааллын асуудлыг шийдвэрлэх зорилготой.

Энэхүү журам нь бүтцийн хувьд 8 зүйл 50 заалтаас бүрдэнэ.

Нэг. Нийтлэг үндэслэл

Хоёр. Эдийн засаг, нийгмийн хөгжлийн санг бүрдүүлэх эх үүсвэр

Гурав. Сангийн зөвлөл

Дөрөв. Сангийн хуваарилалт

Тав. Сангийн зарцуулалт

Зургаа, Хяналтын зөвлөл

Долоо. Хариуцлага

Найм. Бусад

Хурлын дарга Б.Жавхлан: Энэ журмыг ТУЗ-ийн хурлаар дахин хэлэлцсэн үү?

Захиргаа хүний нөөцийн хэлтсийн дарга Л.Шагдарсүрэн: Хурлаар хэлэлцсэн ер нь сантай болох эрхзүйн үндэслэл бий болсон учир Хувьцаа эзэмшигчдийн хөрөнгийг зарцуулах асуудал болохоор ээлжит бус хурлаар оруулж шийдвэрлүүлэх чиглэл өгсөн.

Хурлын дарга Б.Жавхлан: Очирлхам даргаа 2015 оны төлөвлөгөөнд чинь энэ агуулгаар тусгагдсан зүйл байгаа юу

Санхүү эдийн засгийн хэлтсийн дарга Ч.Очирлхам: Байхгүй.

Захиргаа хүний нөөцийн хэлтсийн дарга Л.Шагдарсүрэн: Журам батлагдаагүй учраас төлөвлөгөөнд суулгаагүй.

Хурлын дарга Б.Жавхлан: Энэ сан байх нь зайлшгүй шаардлагатай. Эдийн засгийн гэдэг үг нэрэнд байх шаардлагатай юу санал шүү? Хувьцаа эзэмшигчдийн хурлаар энэ асуудлыг шийдвэрлэх шаардлагатай юу? Энэ хурлаар ийм жижиг асуудал руу орох бол болохгүй? ТУЗ буруу шийдвэр гаргасан юм шиг байх юм.

ТУЗ-ийн гишүүн Л.Ганболд: ТУЗ-ийн эрх мэдлийн хүрээнд журмыг батлаад явах боломжтой. Сан гэхээр хөрөнгө зарцуулах учраас ТУЗ-ийн эрх хэмжээний асуудал

биш юм гэж үзээд хөрөнгийн эзэмшигч нь Хувьцаа эзэмшигч учраас ээлжит бус хурлаар шийдвэрлэх нь зүйтэй гэж үзсэн.

Хурлын дарга Б.Жавхлан: Зарчмын хувьд дэмжээд ТУЗ-д Сантай болох асуудлыг 1 дүгээр улиралд багтаан шийдвэрлэ гэсэн үүрэг өгөөд томъёолох нь зүйтэй. Энэ бол зайлшгүй хийх шаардлагатай. Цаашид уурхайчдад нийгмийн хөгжлийн сантай байвал зүйтэй гэсэн саналтай байна.

Хувьцаа эзэмшигч Ж.Цэдэнсодном: Багануурт байгаа томоохон үйлдвэрийн газруудад дүүрэг орон нутгаас газар өгөх чиглэл гарсан байна лээ? Энэ бол мэдээлэл сантай байх нь зүйтэй гэж үзэж байна.

Хурлын дарга Б.Жавхлан: Хэрвээ Хувь нийлүүлэгчдийн хурлын шийдвэрээр явбал энэ нь процессын хувьд их хүнд сурталтай болно. Жилдээ ганц хуралддаг хурал болохоор энэ асуудлыг ТУЗ-өөр шийдвэрлэсэн нь дээр. Санг бүрдүүлэх асуудал бол нийтлэг байдаг бөгөөд харин зарцуулалтаа сайн тодорхой болгох хэрэгтэй. Энэ хүмүүстээ их өгөөжтэй байх хэрэгтэй. ТУЗ шийдвэрлээд явбал дор дор нь хүндрэл багатай шийдвэрлэнэ.

Хувьцаа эзэмшигч С.Цэлмэг: Зарчмын хувьд дэмжээд ТУЗ-д уг эрхийг нь олгоод зарчмын шийдэл гаргах хэрэгтэй. Нэгэнт энэ асуудал руу орсон дээр асуух зүйлээ асууя. Журмын 2.1.2-2.1.4 заасан эх үүсвэрийг бүрдүүлэх хэдэн төгрөг санд төвлөрөх боломжтой вэ?

Захиргаа хүний нөөцийн хэлтсийн дарга Л.Шагдарсүрэн: Та бүхэнд өгсөн хүснэгтэд байгаа 2014 онд буюу жилдээ 335,9 сая төгрөг төвлөрөх боломжтой.

Хурлын дарга Б.Жавхлан: 2014, 2015 онуудад 700 сая төгрөг бүрдүүлэх боломжтой гэсэн үг үү, Зарчмын хувьд дэмжиж байна гэж Төлөөлөн удирдах зөвлөлд үүрэг болговол яасан юм бэ? Санал өгөх үү? Журам батлахаас татгалзах шийдвэр гаргаад харин зарчмын хувьд дэмжиж ТУЗ-д эрх олгох шийдвэр гаргах нь зүйтэй юу? Энэхүү журмын зорилго болон агуулга, үндэслэлийг хувьцаа эзэмшигчид дэмжиж батлах шаардлагатай гэж үзэж байна.

Эдийн засаг нийгмийн хөгжлийн сангийн журам батлах асуудлаар тооллогын комисс ажиллан тооллогын комиссын 4 дүгээр тогтоолыг танилцуулж хувьцаа эзэмшигчдийн 100 хувь татгалзсан саналаар журмын төслийг батлаагүй. Харин Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаас сантай байх түүнийг журамлах асуудлыг дэмжиж Төлөөлөн удирдах зөвлөлд эрх олгох тухай тогтоол гарган хувьцаа эзэмшигчдийн 100 хувийн саналаар баталлаа.

Хурлын дарга Б.Жавхлан 17.50 цагт хурлыг хааж Багануур ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал амжилттай болж дууссан тухай мэдэгдэж хуралд оролцогсодод ажлын амжилт хүслээ.

Хурлын тэмдэглэл хөтөлсөн. Хуулийн зөвлөх

Д.Ганчимэг

Хурлын тэмдэглэлтэй танилцсан. Хурлын дарга

Б.Жавхлан